



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 14

Сүхбаатар сум

Комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 66 дугаар зүйлийн 66.1.11, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5.3, 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 3.1, 2020 оны 141 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.2021 оны 11 дүгээр сарын 2, 3, 4-ний өдрүүдэд зохион байгуулагдах төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

Б.Болорзул - Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Ш.Энхмаа -Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

Д.Ёндонжамц -Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

М.Нямсүрэн -Салбар зөвлөлийн гишүүн, Шүүхийн Тамгын газрын дарга

Б.Саруултөгс -Салбар зөвлөлийн гишүүн, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Техникийн ажлын хэсэг:

Ч.Гандүүрэн -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

мэдээллийн технологи хариуцсан  
мэргэжилтэн

Д.Ариундэлгэр

-Мөн хэлтсийн хүний нөөцийн асуудал  
хариуцсан мэргэжилтэн

Б.Янжинлхам

-Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

С.Жавзанжамба

-Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын хэлтсийн мэргэжилтэн

2.Шалгалтыг зохих журмын дагуу зохион байгуулж, дүнг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэрийг холбогдох газарт хүргүүлж, хяналт тавьж ажиллахыг комиссын дарга /Б.Болорзул/, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ш.Энхмаа/ нарт даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА